

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлагналын аудит
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХЭДС	Хөдөлмөр, эрхлэлтийн дэмжих сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХАОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. Аудитын тайлан.....	16
3.1. Ерөнхий зүйл.....	16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилт.....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
4. Менежментийн захидал	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Э.ТАМИР ТАНАА

2021.02.25 № 07/403
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Азийн хөгжлийн банкны хэрэгжүүлж буй Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл болон Нэгдсэн үндэсний байгууллагаас тайлант онд хандив тусламжаар хүлээн авсан бараа материал, хөрөнгийн үнэ нь зах зээлийн үнээс мэдэгдэхүйц хэмжээний өндөр байна. Энэ нь байгууллагын удирдлагын шийдвэртэй холбоогүй боловч хөрөнгийн дүнд нөлөө үзүүлж байгааг бид энэ хэсэгт мэдээлж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буюу илэрхийллээс байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй үндэслэлтэй материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,118,741.00</u>	<u>43,385,797.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,247.00	3,637.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,247.00	3,637.00
3121	Төгрөг	9,247.00	3,637.00
31213	Арилжааны банк дахь харилцах	9,247.00	3,637.00
33	АВЛАГА	-	17,042,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	17,042,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,109,494.00	26,340,160.00
354	Хангамжийн материал	10,109,494.00	26,340,160.00
35410	Бичиг хэргийн материал	9,229,448.00	11,934,440.00
35420	Аж ахуйн материал	595,850.00	277,000.00
35470	Бусад хангамжийн материал	284,196.00	14,128,720.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,785,825,026.83</u>	<u>6,597,217,273.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,785,825,026.83	6,597,217,273.72
392	Биет хөрөнгө	6,718,456,160.20	6,513,844,316.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,558,034,247.00	6,558,034,247.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(247,490,450.76)	(494,980,901.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	308,400,000.00	308,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,683,333.36)	(48,523,333.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,752,327.48	195,763,587.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,807,127.22)	(48,822,413.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,196,056.96	60,239,046.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,926,494.89)	(33,304,346.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,388,635.00	15,603,635.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,407,700.01)	(6,565,205.05)
39217	Ном	8,000,000.00	8,000,000.00
393	Биет бус хөрөнгө	67,368,866.63	83,372,957.54
39301	Програм хангамж	-	17,309,090.91
39303	Бусад биет бус хөрөнгө	68,532,700.00	68,532,700.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,163,833.37)	(2,468,833.37)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,795,943,767.83</u>	<u>6,640,603,070.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>459,600.00</u>	<u>4,001,047.18</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	459,600.00	4,001,047.18
413	Өглөг	459,600.00	4,001,047.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	459,600.00	4,001,047.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,795,484,167.83</u>	<u>6,636,602,023.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,795,484,167.83	6,636,602,023.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,474,849,925.14	1,474,849,925.14
51101	Өмч: - төрийн	1,474,849,925.14	1,474,849,925.14
512	Хуримтлагдсан үр дүн	113,638,235.75	(45,243,908.54)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	47,199,920.46	117,812,235.75
51220	Тайлант үеийн үр дүн	66,438,315.29	(163,056,144.29)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,206,996,006.94	5,206,996,006.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,795,943,767.83</u>	<u>6,640,603,070.72</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,449,563,425.00	1,116,127,913.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,410,425.00	163,938,513.81
120	Нийтлэг татварын бус орлого	109,410,425.00	163,938,513.81
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	109,057,225.00	100,259,351.71
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,213.00	0.80
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	108,998,012.00	100,259,350.91
120009	Бусад орлого		6,150,000.80
120011	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	353,200.00	57,529,162.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,340,153,000.00	952,189,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,339,805,000.00	911,417,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,339,805,000.00	911,417,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,000.00	40,772,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,772,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	348,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,383,125,109.71	1,279,184,058.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,383,125,109.71	1,279,184,058.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,363,631,237.98	1,172,470,997.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	518,191,859.42	445,019,582.55
210101	Үндсэн цалин	518,191,859.42	444,058,291.55
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	961,291.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,257,972.43	57,312,975.07
210201	Тэтгэврийн даатгал	46,107,650.64	41,438,639.26
210202	Тэтгэмжийн даатгал	5,165,142.98	4,433,352.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,132,114.38	3,546,681.98
210204	Ажилгүйдлийн даатгал	895,733.13	717,663.67
210205	Эрүүл мэндийн даатгал	8,957,331.30	7,176,637.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,984,039.87	45,521,225.00
210301	Гэрэл, цахилгаан	22,620,092.00	19,373,520.60
210302	Түлш, халаалт	14,561,476.64	16,132,526.69
210303	Цэвэр, бохир ус	13,802,471.23	10,015,177.71
2104	Хангамж, бараа материалын зардал	94,043,737.74	108,838,179.60
210401	Бичиг хэрэг	10,130,363.00	11,206,718.00
210402	Тээвэр, шатахуун	5,411,000.00	9,773,705.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,027,183.74	10,058,180.50
210404	Ном, хэвлэл	48,140,000.00	3,000,000.00

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	9,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,335,191.00	64,999,576.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,482,950.00	8,272,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,416,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,024,050.00	500,000.00
210604	Урсгал засвар	26,042,900.00	7,772,100.00
2107	Томилолт, зочны зардал	15,312,000.00	18,350,000.00
210702	Дотоод албан томилолт	15,312,000.00	18,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,224,458,479.81	179,970,841.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,219,839,559.81	169,855,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	107,591.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	1,919,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	318,900,198.71	309,186,094.02
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,724,361.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	290,175,837.71	309,186,094.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,493,871.73	106,713,060.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,393,871.73	106,713,060.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,393,871.73	106,713,060.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>66,438,315.29</u>	<u>(163,056,144.29)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>66,438,315.29</u>	<u>(163,056,144.29)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,340,212,213.00</u>	<u>956,363,400.80</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,213.00	4,174,000.80
120	Нийтлэг татварын бус орлого	59,213.00	4,174,000.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,213.00	4,174,000.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,213.00	4,174,000.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,340,153,000.00	952,189,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,339,805,000.00	911,417,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,339,805,000.00	911,417,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,000.00	40,772,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	40,772,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	348,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,097,652,966.00</u>	<u>936,050,020.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,097,652,966.00	936,050,020.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,078,159,094.27	812,294,959.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,732,258.23	445,233,284.46
210101	Үндсэн цалин	388,579,246.23	331,531,571.70
210102	Нэмэгдэл	85,741,432.00	78,388,287.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,411,580.00	35,313,425.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,257,972.43	53,557,825.98
210201	Тэтгэврийн даатгал	49,995,584.19	37,674,534.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,985,032.14	4,398,371.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,072,370.94	3,345,673.27
210204	Ажилгүйдлийн даатгал	1,851,049.39	1,243,269.96
210205	Эрүүл мэндийн даатгал	7,353,935.77	6,895,976.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,984,039.87	45,521,225.00
210301	Гэрэл, цахилгаан	22,620,092.00	19,373,520.60
210302	Түлш, халаалт	14,561,476.64	16,132,526.69
210303	Цэвэр, бохир ус	13,802,471.23	10,015,177.71
2104	Хангамж, бараа материалын зардал	95,010,629.74	54,410,773.50
210401	Бичиг хэрэг	10,419,811.00	5,194,910.00
210402	Тээвэр, шатахуун	5,411,000.00	4,989,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,027,183.74	10,058,180.50
210404	Ном, хэвлэл	48,140,000.00	3,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	342,400.00	9,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,670,235.00	21,367,783.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,482,950.00	8,272,100.00

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	49,416,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,024,050.00	500,000.00
210604	Урсгал засвар	26,042,900.00	7,772,100.00
2107	Томилолт, зочны зардал	15,312,000.00	18,350,000.00
210702	Дотоод албан томилолт	15,312,000.00	18,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,228,654,883.00	186,949,751.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,224,035,963.00	176,833,910.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	106,920.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	107,591.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	1,919,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,724,361.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,724,361.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,493,871.73	123,755,060.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	100,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,393,871.73	123,755,060.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,393,871.73	123,755,060.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>242,559,247.00</u>	<u>20,313,380.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	242,558,000.00	20,318,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	242,558,000.00	20,318,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	242,558,000.00	20,318,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	242,558,000.00	20,318,990.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(242,558,000.00)</u>	<u>(20,318,990.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,247.00	(5,610.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,000.00	9,247.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,247.00	3,637.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	47,199,920.46	6,729,045,852.54
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	47,199,920.46	6,729,045,852.54
Тайлант үеийн үр дүн	-	-	66,438,315.29	66,438,315.29
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	113,638,235.75	6,795,484,167.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,174,000.00	4,174,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	117,812,235.75	6,799,658,167.83
Тайлант үеийн үр дүн	-	-	(163,056,144.29)	(163,056,144.29)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,474,849,925.14	5,206,996,006.94	(45,243,908.54)	6,636,602,023.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/тəгрəгəər/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	911,417,400.00	808,883,949.94	102,533,450.06	88.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	911,417,400.00	808,883,949.94	102,533,450.06	88.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	910,699,900.00	808,883,949.94	101,815,950.06	88.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,786,700.00	445,233,284.46	44,553,415.54	90.90
210101	Үндсэн цалин	362,840,700.00	331,531,571.70	31,309,128.30	91.37
210102	Нэмэгдэл	98,648,500.00	78,388,287.74	20,260,212.26	79.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,297,500.00	35,313,425.02	(7,015,925.02)	124.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,121,400.00	53,557,825.98	12,563,574.02	81.00
210201	Тэтгэврийн даатгал	46,529,800.00	37,674,534.77	8,855,265.23	80.97
210202	Тэтгэмжийн даатгал	4,897,900.00	4,398,371.87	499,528.13	89.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,918,200.00	3,345,673.27	572,526.73	85.39
210204	Ажилгүйдлийн даатгал	979,700.00	1,243,269.96	(263,569.96)	126.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,795,800.00	6,895,976.11	2,899,823.89	70.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,668,300.00	45,521,225.00	25,147,075.00	64.42
210301	Гэрэл, цахилгаан	26,956,800.00	19,373,520.60	7,583,279.40	71.87
210302	Түлш, халаалт	26,039,700.00	16,132,526.69	9,907,173.31	61.95
210303	Цэвэр, бохир ус	17,671,800.00	10,015,177.71	7,656,622.29	56.67
2104	Хангамж, бараа материалын зардал	59,058,700.00	55,410,763.50	3,647,936.50	93.82
210401	Бичиг хэрэг	6,375,500.00	5,194,910.00	1,180,590.00	81.48
210402	Тээвэр, шатахуун	4,989,900.00	4,989,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,281,600.00	10,058,180.50	1,223,419.50	89.16
210404	Ном, хэвлэл	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,000,000.00	9,800,000.00	200,000.00	98.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,411,700.00	22,367,773.00	1,043,927.00	95.54

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,294,900.00	8,272,100.00	22,800.00	99.73
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	7,794,900.00	7,772,100.00	22,800.00	99.71
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	216,769,900.00	200,888,751.00	15,881,149.00	92.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,527,900.00	190,772,910.00	14,754,990.00	92.82
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	375,300.00	89,100.00	286,200.00	23.74
210804	Тээврийн хэрэгслийн татвар	255,700.00	107,591.00	148,109.00	42.08
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-	121,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,490,000.00	1,919,150.00	570,850.00	77.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	717,500.00	-	717,500.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	717,500.00	-	717,500.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	717,500.00	-	717,500.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	911,417,400.00	808,878,339.94	102,539,060.06	88.75
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	911,417,400.00	804,704,339.14	106,713,060.86	88.29
131001	Улсын төсвөөс санхүүжих	911,417,400.00	804,704,339.14	106,713,060.86	88.29
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	4,174,000.80	(4,174,000.80)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,174,000.80	(4,174,000.80)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	9,247.00	(9,247.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,637.00	(3,637.00)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	-	100.00

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620001	Удирдах ажилтан	6	6	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,772,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		40,772,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		23,730,000.00
2107	Томилолт, зочны зардал		18,350,000.00
210702	Дотоод албан томилолт		18,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,380,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,380,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		17,042,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		17,042,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		40,772,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		40,772,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		40,772,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Э.Тамир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн бүртгэл, тооцоолол үлдэх өртгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 1/11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөгжлийн дэмжих
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжил, хамгааллын талаарх Засгийн газрын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцоо тэгш эрхийг хангах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын хуульд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 112,499.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай байгаа бөгөөд зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажлын уялдаа, бүтэц зохион байгуулалтыг сайжруулан ажилласан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,230,681.3 мянган төгрөгөөс тооцон 24,613.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн залруулсан дүн 1,279,184.1 мянган төгрөгийн 2 хувиар тооцон 25,583.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 155,340.7 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	9.2	3.6	(5.6)
Авлага		17,042.0	17,042.0
Бараа материал	10,109.5	26,340.2	16,230.7
Үндсэн хөрөнгө	6,785,825.0	6,597,217.3	(188,607.8)
Нийт хөрөнгө	6,795,943.8	6,640,603.1	(155,340.7)
Өр төлбөр	459.6	4,001.0	3,541.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,795,484.2	6,636,602.0	(158,882.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,795,943.8	6,640,603.1	(155,340.7)

Азийн хөгжлийн банкны 14,074.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэл болон Нэгдсэн Үндэсний байгууллагын төслийн санхүүжилтийн 2,970.0 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснээс авлагын үлдэгдэл 17,042.0 мянган төгрөгөөр 2020 онд өсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 26,340.2 мянган төгрөг болж 16,230.7 мянган төгрөгөөр өссөн нь Нэгдсэн Үндэсний байгууллагын тусламж, санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан живх, дэвсгэр олгосныг Ковид-19 цар тахлаас шалтгаалан тарааж чадаагүйгээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 100,259.4 мянган төгрөг, худалдан авсан 20,319.0 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Тайлант онд Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авсан 17,309.1 мянган төгрөгийн 2 жилийн хугацаатай вирусийн программ хүлээн авснаас биет бус хөрөнгө өссөн.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,001.0 мянган төгрөг болж өссөн нь Нийгмийн даатгалын шимтгэлийн өр 3,755.2 мянган төгрөг, Хүн амын орлогын албан татварын 245.8 мянган төгрөгийг оны эцэст төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,636,602.0 мянган төгрөг болж 158,882.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,333,434.5 мянган төгрөгөөр буюу 45.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Ази, Номхон далайн бүсийн орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн IV-р конгрессыг Улаанбаатар хотод зохион байгуулахтай холбоотой зардлыг улсын төсвийн орлогоос санхүүжүүлсэнтэй холбоотой өнгөрсөн онд өссөн байсан.

Нийт зардал өмнөх оноос 1,124,924.6 мянган төгрөгөөр буюу 52.8 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 4,174.0 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн залруулгад бүртгэсэн нь өмнөх онд гүйцэтгэсэн ХЭДС-ийн төслийн үйл ажиллагааг хангалтгүй гүйцэтгэсэн газруудаас гэрээний дагуу эргэн төлүүлсэн төлбөртэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 911,417.4 мянган төгрөгөөр тооцон нийт зарлагыг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 911,417.4 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвийн орлогоор 100 хувь санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 911,417.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 4,174.0 мянган төгрөг нийт 915,591.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 808,883.9 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 102,533.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 808,883.9 мянган төгрөг буюу 88.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 44,553.4 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,563.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 25,147.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 3,647.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 15,881.1 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүй. Энэ нь хорио цээрийн дэглэмтэй холбоотой төсөвлөсөн сургалт, арга хэмжээг зохион байгуулагдаагүйтэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Азийн хөгжлийн банкны тусламж хандиваар 32,422.0 мянган төгрөг, НҮБ-ийн хандив тусламжаар 8,350.0 мянган төгрөг нийт 40,772.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс орон нутагт ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэнг сургах сургалтын томилолт, унааны зардалд 18,350.0 мянган төгрөг, Сүхбаатар дүүргийн Засаг Даргын Тамгын газар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын нийтийн эзэмшлийн талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай авто зогсоол барихад зориулан 5,380.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 17,042.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс 100 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журналын орлого, зарлагын гүйлгээтэй тулгаж үзэхэд зөрүүтэй мэдээлэл илрээгүй бөгөөд хуулиар шаардсан бүх мэдээллийг байршуулж, тушаал шийдвэрүүдийг иж бүрэн оруулж ажилласан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,898.2 мянган төгрөгийн албан шаардлага, 16,075.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс албан шаардлагын биелэлт 73.7 хувь, 10,824.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжүүлж, 5,251.3 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй ба нийт зөвлөмжийн хэрэгжилт 62.7 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт							
Албан шаардлага	1	1,898.2	1	1,398.2	1	500.0	73.7
Зөвлөмж	3	16,075.7	3	15,025.4	3	1,050.3	62.7
Нийт дүн	4	17,973.9	4	16,354.1	4	1,619.8	

/мянган.төг/

Өмнөх аудитаар илрүүлсэн мөнгөн хөрөнгийн зарлагын и-баримтыг цахим төлбөрийн баримтын системд шивж оруулаагүй зөрчил тайлант хугацаанд давтагдаж гарсанд албан шаардлага хүргүүлж, түлш шатахууны хэмнэлт хэтрэлтийн тооцоог хийгээгүй зөрчил давтан гарсанд төлбөрийн акт тогтоов.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 77,711.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 64,177.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 500.0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 7,200.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5,834.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. НҮБ-ын тусламжаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараах 57,349.4 мянган төгрөгийн живх, дэвсгэрийг бараа материалын орлогод бүртгээгүйг залруулан орлого зарлагад бүртгэн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусган залруулав.
2. Жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлд эд хариуцагч дээр бүртгэлтэй байсан 2,826.9 мянган төгрөгийн хангамжийн материалыг тооллогын бүртгэлд нэгтгэж оруулаагүйг тооллогод хамруулан залруулсан.
3. НДШ-ийн тооцоо нийлсэн актын дүн 3,755.2 мянган төгрөг, ХХОАТ-ын тайлангийн төлбөл зохих татварын өрийн үлдэгдэл 245.8 мянган төгрөг нийт 4,001.0 мянган төгрөгийн өрийг санхүүгийн тайланд тусгуулж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 13,534.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 500.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,200.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Цахим баримтын ebarimt.mn системийн 158,108.8 мянган төгрөгийн и-баримтыг зарлагын баримтуудтай тулгахад 7,200.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ." гэсэн заалт, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: И-баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчилд өмнөх жилийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн ч давтагдсан уг зөрчилд албан шаардлага хүргүүлж байна.

2. Шатахууны зарцуулалт огт хангаагүй, 500.0 мянган төгрөгийн хэмнэлт хэтрэлтийн тооцоог бодолгүй зардалд шууд бүртгэн тайлагнасан нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалын нэгдүгээр хавсралт Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 заасан "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтууд, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр

толилуулах үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны хэтрэлт хэмнэлтийг тооцоогүй зөрчилд нөхөн төлбөрийн акт тогтоов.

3. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах мэдээллээс 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5,834.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацааны үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа 15 нэр төрлийн 5,834.0 мянган төгрөгийн компьютер түүний дагалдах хэрэгслүүд элэгдлээ бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон байна. Энэ нь УСНББОУС17-ийн 44-д “Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана” заалттай нийцээгүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 19 өдрийн 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 6 дугаар зүйл “Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах” журмыг хэрэгжүүлээгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдэл хангагдахгүй байх эрсдэл.

4.1.3 Өгсөн зөвлөмж

Элэгдлээ бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон ч цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх, харин ашиглах боломжгүй хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж данс бүртгэлээс хасах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/155/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим хуудсанд 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан		Албан шаардлага	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
2	Элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй компьютер, түүний дагалдах хэрэгслүүд бүртгэлд байна.	5,834.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
3	Төлбөр тооцоог гүйцэтгэхдээ төлбөрийн е-баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй.	7,200.0	Албан шаардлага	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
4	Шатахууны зарцуулалтыг хянахдаа хэтрэлт, хэмнэлтийн тооцоог хийгээгүй.	500.0	Акт тогтоох	Ерөнхий нягтлан бодогч	Ж.Хаш-Эрдэнэ
ДҮН		13,534.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 50/A0170065

Улаанбаатар хот

свт-2021/55/СТП.ТЧЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шатахууны зарцуулалтаа хянаагүй, хэтрэлт хэмнэлт тооцоогүй, шууд зардалд бүртгэн тайлагнасан 500.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалаар батлагдсан Жишиг норм батлах тухай журмын нэгдүгээр хавсралтад "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахууны зарцуулалтыг хянаж, хэтрэлт хэмнэлтийн тооцоог хийж, хяналт тавилгүй шууд зардалд бүртгэсэн 500,000 /Таван зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Э.Тамир Ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.БАТ-ЭРДЭНЭ
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Gazar37.Docx

001090493



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 177/АД/20065
СЭН-2021/155/СТА-ТЧЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 147 мэдээллээс 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Э.Тамир, Ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.БАТ-ЭРДЭНЭ

Ч.ЭРДЭНЭЖАВ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 178/АД/70065
САР-20 21/455/СТА-ТМЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Цахим баримтын ebarimt.mn системийн 158,108.8 мянган төгрөгийн зарлагыг баримтуудтай тулгахад 7,200.0 мянган төгрөгийн и-баримтыг шивээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, и-баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Э.Тамир, Ерөнхий нягтлан бодогч Ж.Хаш-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.БАТ-ЭРДЭНЭ

Ч.ЭРДЭНЭЖАВ

[illegible]